

# Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт холбогдох татварын асуудлууд

## Холбоо барих:

### Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
[sergi.kobakhidze@pwc.com](mailto:sergi.kobakhidze@pwc.com)

### Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх  
үйлчилгээ  
[tsendmaa.choijamts@pwc.com](mailto:tsendmaa.choijamts@pwc.com)

### Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Хуулийн зөвлөх үйлчилгээ  
[munkhjargal.ragchaakhuu@pwc.com](mailto:munkhjargal.ragchaakhuu@pwc.com)

### Эрдэнэ-Очирын Энхсанаа

Татварын менежер  
Татварын зөвлөх үйлчилгээ  
[enkhसानаа.erdene-ochir@pwc.com](mailto:enkhसानаа.erdene-ochir@pwc.com)

### Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс  
Легал ХХН

ПрайсуотэрхаусКүүпэрс Такс  
ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)



## Хураангуй

2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсан. Тус хууль нь үндэсний баялгийн санг хэрхэн бүрдүүлэх, хуваарилах, удирдах, эдгээртэй холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан ба газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээхэд чиглэгдсэн гэж заажээ.

Тэгвэл энэхүү хууль батлагдсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт (“Нэмэлт Өөрчлөлт”)-ийг оруулсан ба уг нэмэлт өөрчлөлтийн дагуу шинээр орсон голлох заалтууд болон татварын холбогдох өөрчлөлтүүдийг үүгээр онцолж байна.



## Ашигт малтмалын тухай хуульд нэмэлтээр орсон голлох шинэ зохицуулалтууд

### Хувьцаанд хязгаарлалт тогтоосон нь

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 02 сарын 06-ны өдөр баталсан 27 дугаар тогтоолоор 16 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан байдаг.

Тэгвэл Нэмэлт Өөрчлөлтийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны **34-өөс дээш** хувийг аливаа этгээд (үүнд Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд болон төрийн өмчит хуулийн этгээд хамаарахгүй болно) дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг **хориглосон**.

Энэхүү шинэ шаардлагыг биелүүлэх хугацааг хуульд зааж өгөөгүй байна.

### Бүрэн эрхт төлөөлөгч

Дээрх шаардлагыг биелүүлээгүй нь төрөөс бүрэн эрхт төлөөлөгч томилох үндэслэл болох ба бүрэн эрхт төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийг удирдах, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -ийг илэрхийлнэ.



## Ашигт малтмалын тухай хуульд нэмэлтээр орсон голлох шинэ зохицуулалтууд (үргэлжлэл)

### Стратегийн ач холбогдол бүхий ордын үүсмэл ордод төр хувьцаа эзэмших




Ашигт малтмалын тухай хуулийн 5.4 болон 5.5 дахь хэсэгт хайгуулын ажлыг улсын төсвийн оролцоотойгоор хийсэн эсэхээс хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг 34 болон 50 хүртэлх байхаар заасан байдаг.

Тэгвэл Нэмэлт Өөрчлөлтийн дагуу тус зохицуулалт нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордоос гадна түүний **үүсмэл ордод** мөн үйлчлэхээр болсон байна. Өөрөөр хэлбэл, төр стратегийн ач холбогдол бүхий ордын үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг дээрх зарчмаар эзэмших юм.

### Хүлээгдэж буй журам

Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор “Бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам”-ыг батлах бөгөөд тус журмыг Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд батална.



## Татварын холбогдох өөрчлөлтүүд

### Албан татварын тусгай хувь хэмжээ

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн эзэмшигч нь хуулийн этгээдийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ бэлэглэх, өв залгамжлалаар өвлүүлэх хэлбэрээр газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн бусдад шилжүүлсэн тохиолдолд **30 хувиар** татвар ногдуулахаар тусгасан байна.



Та дээрх сэдэв болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол бидэнтэй холбоо барина уу. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [ЭНД](#) дарна уу.

